



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*УИХ-ын Төсвийн Байнгын хорооны саналын дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан*

**Утаа бага гаргах түлш боловсруулах зориулалтаар 2009-2010 онд
төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үр дүн**



**Боловсруулсан түлшний өртөг өндөр
борлуулалт хангалтгүй байна**

<p>Тайланг бэлтгэсэн:</p> <p>ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар</p> <p><i>Захирал:</i> <i>Д.Ганбилэг</i></p> <p><i>Аудитын менежер:</i> <i>Х.Баярмаа</i></p> <p><i>Аудитор:</i> <i>Ш.Отгонбаяр</i> <i>Г.Гүнжидмаа</i></p> <p>Нийслэлийн аудитын газар</p> <p><i>Шинжээч:</i> <i>З.Болд</i></p> <p>2010 оны 10 дугаар сар</p> <p>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</p> <p>www.mnao.mn</p> <p><i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i></p> <p>ХАЯГ: Үндэсний аудитын газар 210642 Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт 2</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 3</p> <hr/> <p>Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор 2009 онд нийслэлийн төсвөөс 3.2 тэрбум, 2010 онд улсын төсвөөс 5.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөжээ</p> <p>Үртсэн түлшний иж бүрэн цогцолбор үйлдвэрийн үйл ажиллагаа жигдрээгүй байна..... 4</p> <p>2009 онд үртсэн шахмал түлшний үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлж, түлшний нөөц бий болгох, 2010-2011 онд гэр хорооллын 15 хувийг боловсруулсан түлшээр хангахаар тооцжээ..... 6</p> <p>Нийслэлийн төвийн зарим дүүргийн нам даралтын халаалтын зууханд техник, технологийн шинэчлэлт хийжээ..... 7</p> <p>Газрын гүний дулааныг ашиглах дэд төсөл бараа, ажил үйлчилгээ худалдан авах аргыг хуулийн дагуу сонгоогүй байна..... 8</p> <p>2010 оны төсвийн тухай хуулинд 5.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр тусгагдсан ч 2010 оны 9 дүгээр сарын байдлаар хөрөнгө зарцуулагдаагүй байна..... 8</p> <p>Аудитын дүгнэлт 11</p> <p>Холбогдох байгууллагын санал:</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн санал .. 12</p> <p>Зөвлөмж 18</p>
--	---

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
МУХС	Монгол Улсыг хөгжүүлэх сан
НАЧА	Нийслэлийн Агаарын чанарын алба
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СБД	Сүхбаатар дүүрэг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны санал, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газар, аймаг, нийслэлийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Утаа бага гаргах зориулалт бүхий түлш боловсруулахаар 2009, 2010 онд төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд аудит хийж, санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Утаа бага гаргах зориулалт бүхий түлш боловсруулахаар санхүүжүүлсэн хөрөнгийг үр ашигтай зарцуулсан эсэх
- Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр үр дүн гарсан эсэх

Хамарсан хүрээ

Аудитад ЭБЭХЯ, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Агаарын чанарын алба, төсөл хэрэгжүүлсэн зарим аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан болно.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Аудитад хамрагдсан болон холбогдох бусад байгууллагуудын албан тушаалтнууд, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, судлах;
- Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ, гүйцэтгэлийг түүвэрлэн шалгах;
- Зарим төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, төсөл, тендерийн баримт материалыг шалгах;
- Цуглуулсан мэдээ судалгаанд дүн шинжилгээ хийх;

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор 2009 онд нийслэлийн төсвөөс 3.2 тэрбум, 2010 онд улсын төсвөөс 5.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

1.1 2009 онд Улсын төсөв, МУХС-гаас агаарын бохирдлыг бууруулах талаар хөрөнгө төлөвлөж зарцуулаагүй байна.

1.2 Харин НИТХ-ын 2009 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн “Нийслэлийн 2008 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” 3/20 дугаар тогтоолоор төсвийн харилцах дансны үлдэгдэл 3.2 тэрбум төгрөгийг агаарын бохирдлыг бууруулах төсөл, арга хэмжээнд зарцуулахаар шийдвэрлэж, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 305 дугаар тогтоолоор төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан байна.

Д.д	Төсөл, арга хэмжээний нэр	Байршил	Хөрөнгө оруулалтын хэмжээ (сая.төг)
1	Үртсэн шахмал түлшний иж бүрэн цогцолбор үйлдвэр шинээр байгуулах	Улаанбаатар хот, орон нутагт байгуулна	1690.0
2	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор одоо ажиллаж байгаа үртсэн шахмал түлшний үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэн, үртсэн түлшний нөөц бий болгох	Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон, Булган аймгийн Хялганат тосгон	70.0
		Улаанбаатар хот	10.0
3	Нийслэлийн төвийн дүүргийн нам даралтын халаалтын зууханд техник, технологийн шинэчлэлт хийх	Хан-Уул, Баянгол дүүрэг	890.0
4	Агаарын бохирдлыг бууруулах дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	Тээврийн хэрэгсэлд шингэрүүлсэн нефтийн хийг нэвтрүүлэх	190.0
		Халаалтын зуухны ашиглалт зохицуулалтын газрын харьяа нам даралтын халаалтын зуухны урсгал засварын зардал	250.0
		Газрын гүний дулааныг дулаан хангамжид нэвтрүүлэх	100.0
Нийт дүн			3200.0

1.Үртсэн шахмал түлшний иж бүрэн цогцолбор үйлдвэрийн үйл ажиллагаа жигдрээгүй байна.

1.3 Нийслэлийн Засаг даргын 2009 оны 309 дүгээр захирамжаар байгуулсан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо 2009 оны 7 дугаар сарын 2-ны өдөр хуралдаж, үртсэн шахмал түлшний үйлдвэрийн иж бүрэн тоног төхөөрөмж худалдан авч суурилуулах тендер зарлахаар шийдвэрлэж, мөн уг үйлдвэр байгуулах газрыг сонгох, үйлдвэрийн газарт аюулгүй бүсийн хашаа барих, эрчим хүчинд холбох, агаарын болон бохир усны шугам татах, трансформатор байрлуулах, цэвэр усны худаг гаргах, үйлдвэрийн болон ажилчдын байр, түүхий эдийн агуулах, вагонд ачиж, буулгах объект барихыг Улаанбаатар бизнес хөгжлийн төв (НӨҮГ)-т даалгасан байна.

1.4 НАЧА-аас боловсруулсан үртсэн шахмал түлшний тоног, төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах тендерийн баримт бичигт сонирхогч талууд тендерт оролцох саналаа 8 дугаар сарын 6-ны өдрийн 11 цагаас өмнө ирүүлэхээр заажээ.

1.5 Гэтэл үнэлгээний хороо 2009 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар “Үртсэн шахмал түлшний үйлдвэр байгуулах тендерийн материал худалдан авсан аж ахуйн нэгжүүд тендерийн саналаа 2009 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 11 цагаас өмнө ирүүлэх, үйлдвэрийн тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажлыг 2009 оны 12 дугаар сарын 1-ний дотор дуусгах, үйлдвэрийн барилга байгууламж, цахилгаан хангамжийг иж бүрнээр нь шийдвэрлэх болсныг мэдэгдэх” гэж шийдвэрлэжээ.

1.6 Энэ нь төслийн хөрөнгөөр ямар объект, барилга байгууламж барихыг тодорхойгүй болгосон байна. Төсөл, арга хэмжээний захиалагч НАЧА үртсэн шахмал түлшний иж бүрэн үйлдвэрийн зураг, төсөвгүй, түүхий эдийн нөөцийг тодорхойлоогүй, эдийн засгийн үр ашгийн хувьд үйлдвэр байгуулсан газрын байрлал нь оновчтой эсэх талаар тооцоолол хийгээгүй байна. Үйлдвэрийг ашиглалтад оруулснаар хотын иргэд үртсэн түлшийг хэрэглээд агаарын бохирдлыг хэдэн хувиар бууруулах талаар хийсэн тооцоо судалгаагүй байна.

1.7 НАЧА 2009 оны 8 дугаар сарын 31-ний 1/237 дугаар албан бичгээр “Номин холдинг”, “Хялганат хангай” ХХК-уудын хамтарсан “Хос гарьд” түншлэлд үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн гэрээ байгуулахыг зөвшөөрснийг мэдэгдсэн байна. Тендерийн баримт материалд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл алга байна.

1.8 НАЧА, НЗДТГ-ын СТСХ, “Номин холдинг”, “Хялганат хангай” ХХК-уудын хамтарсан “Хос гарьд” түншлэлтэй “Үртсэн шахмал түлшний иж бүрэн цогцолбор үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах, үйлдвэрийн барилга байгууламж барих” төсөл арга хэмжээг 1525.7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр АБ2009/06 дугаар гэрээг 2009 оны 9 дүгээр сарын 9-нд байгуулжээ.

1.9 Иж бүрэн цогцолбор үйлдвэр байгуулах хугацааг 2 сар 21 хоног гэж тооцсон боловч улсын комисс 2010 оны 7 дугаар сарын 23-ны өдөр үйлдвэрийг ашиглалтад хүлээн авчээ. Гүйцэтгэгчээс цахилгаан, халаалтын систем бүхий сендвичэн барилга, шахмал түлш үйлдвэрлэгч тоног төхөөрөмж, цэвэр усны гүний худаг хүлээлгэн өгсөн байна.



1.10 Тендерийн баримт бичигт жилд 15000 тн-оос багагүй шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай тоног, төхөөрөмж нийлүүлэхээр заасан боловч “Хос гарьд” түншлэл тендерт оролцохдоо жилд 12500 тн түлш үйлдвэрлэх тоног төхөөрөмж санал болгож суурилуулжээ. Мөн үйлдвэрийн хашаа барих 27.0 сая төгрөгийг нэмж зарцуулахыг үнэлгээний хороо шийдвэрлэж, “Хос гарьд” түншлэлтэй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

1.11 Улаанбаатар бизнес хөгжлийн төв НӨҮГ үйлдвэрийг ажиллуулахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэхээр саналаа НЗДТГ-т ирүүлсний дагуу бэлэн бүтээгдэхүүний агуулах, манаачийн байр барих, ачааны авто машин, ачдаг, түрдэг механизм, уутны ам оёдог машин, нүүрс бутлагч зэрэг тоног төхөөрөмж авах 250.0 сая төгрөгийг олгохоор НИТХ-ын 2010 оны 5/37 дугаар тогтоолоор шийдвэрлэж нэмэлт хөрөнгө зарцуулсан нь Үртсэн шахмал түлшний иж бүрэн цогцолбор үйлдвэрийн зураг, төсөвгүй, тендерийн баримт бичгийг дутуу боловсруулсантай холбоотой байна.



1.12 Үйлдвэр 2010 оны 8 дугаар сарын 27-ноос эхлэн 15 хоногт 70 гаруй тн үртсэн шахмал түлш үйлдвэрлэснийг жилээр тооцож үзвэл 1680 орчим тн түлш үйлдвэрлэхээр байгаа нь гүйцэтгэгчийн тендерт оролцохдоо анх өгсөн саналаас ихээхэн зөрүүтэй байна.

1.13 Үйлдвэрийг технологийн горимын дагуу ажиллуулах мэргэшсэн инженер, техникийн ажилтангүй, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар ажиллуулаагүй байна.

2. 2009 онд үртсэн шахмал түлшний үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлж, түлшний нөөц бий болгох, 2010-2011 онд гэр хорооллын 15 хувийг боловсруулсан түлшээр хангахаар тооцжээ.

1.14 НАЧА-аас 2009 оны зуны улиралд боловсруулсан түлшний нөөц, хуримтлал бий болгох зорилгоор “Өлзийт төв”, “Тара”, “Хүслэн-Өлзий” ХХК-иудтай 2800 тн үртсэн шахмал түлш нийлүүлж 70.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ байгуулсан байна. Гэрээгээр тн тутамд 25.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 2009-2010 оны өвлийн улиралд нэг тн түлшийг 90.0 мянган төгрөгөөр борлуулахаар заасан байна. Үртсэн шахмал түлш борлуулах 150 цэгээр дамжуулан хэрэглэгчдэд түлшийг борлуулсан байна.

1.15 Үртсэн шахмал түлшний нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан 5 сарын хугацаатай агуулах түрээслэхэд 10.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

1.16 Улаанбаатар хотын Засаг даргын 2010 оны 368 дугаар захирамжаар 2010-2011 оны өвлийн улиралд 15600 тн нүүрсэн шахмал, 16200 тн үртсэн шахмал, 50000 тн хагас коксжуулсан түлш нийлүүлэгдэх тул БГД-ийн 9, 10, 11, 16, Чингэлтэй дүүргийн 7,8,9,10,11, СБД-ийн 9,11,12 дугаар хорооны гэр хорооллын айл өрхийг боловсруулсан түлшээр хангах арга хэмжээг авахыг НАЧА-д даалгаж, агаарын бохирдлыг бууруулах бүсчлэл тогтоох тухай Нийслэлийн Засаг даргын 154 дүгээр захирамжаар батлагдсан нэг дүгээр бүсийн нутаг дэвсгэрт боловсруулсан түлшнээс өөр төрлийн түлш хэрэглэхийг хориглосон байна.

1.17 НАЧА 2007-2009 онд төсвөөс боловсруулсан түлшний үйлдвэрлэлийг дэмжих төслийн санхүүжилт авсан нүүрсэн шахмал түлш үйлдвэрлэдэг 4, үртсэн шахмал түлшний 6 аж ахуйн нэгж байгуулагатай түлш нийлүүлэх гэрээ байгуулсан байна.

1.18 Харин хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэдэг “Шарын гол энерго”, “Нако”, “Төгрөгнуурын энерги” ХХК-тай гэрээ хийгдээгүй, нийт 40000 тн түлш нийлүүлнэ гэж тооцон хуваарь хийсэн байна.

1.19 Гэрээнд нэг тонн үртсэн шахмал түлшийг 120.0 мянган төгрөгөөр, нүүрсэн шахмал түлшийг 70.0 мянган төгрөгөөр борлуулахаар заасан байна.

1.20 2010 оны 9 дүгээр сарын байдлаар зах зээлд борлуулагдаж буй түлшний үнийн судалгаа хийхэд үртсэн шахмал түлшний үнэ түүхий нүүрс, түлшний модны үнээс өндөр, зах зээлд төдийлөн танил бус байна. Харин нүүрсэн шахмал түлшний үнэ түүхий нүүрсний үнэтэй ойролцоо боловч илчээ удаан барьдаггүй хэрэглэж дадаагүйгээс айл өрхүүд бараг ашигладаггүй байна.

Зах зээлийн үнэ болон хэрэглэгчдээс авсан үнийн судалгаа

Түлш	Ангилал	Хэмжих нэгж	мян.төг
Түүхий нүүрс	Налайх	тн	90.0-100.0
	Алаг толгой	тн	120.0
Мод	Нарс	Куб.м	12.0
	Хар мод	Куб.м	30.0-50.0
Үртсэн шахмал түлш		тн	120.0
Нүүрсэн шахмал түлш		тн	70.0

1.21 Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаанаас үзэхэд Улаанбаатар хотын хүн амын 27 хувь ядуурлын түвшинд амьдарч байгаа нь боловсруулсан түлш бус түүхий нүүрс хэрэглэсэн хэвээр байх магадлалтай байна.

1.22 Боловсруулсан түлшний өртөг өндөр, илчээ удаан барьдаггүй, сурталчлан таниулах арга хэмжээ хангалтгүй, хэрэглээ нэмэгдэхгүй байгаа зэргээс зохион байгуулж буй ажлын бодитой үр дүн харагдахгүй байна.

3. Нийслэлийн төвийн зарим дүүргийн нам даралтын халаалтын зууханд техник, технологийн шинэчлэлт хийжээ.

1.23 Нам даралтын 4 зууханд техник, технологийн шинэчлэлт хийхээр 890.0 сая төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 807.6 сая төгрөгийн гэрээ байгуулан төсөл арга хэмжээг хэрэгжүүлжээ.

1.24 Нийслэлийн Засаг даргын 2009 оны 309 дүгээр захирамжаар байгуулсан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2009 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн хурлын шийдвэрээр ХУД-ийн нэгдсэн эмнэлэг, БГД-ийн Сэтгэмж цогцолбор сургуулийн нам даралтын халаалтын зууханд техник, технологийн шинэчлэлт хийх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр “Эрчим Импекс” ХХК-ийг сонгон шалгаруулсан боловч уг компани захиалагчтай гэрээ байгуулаагүй тул тендерт оролцож шалгараагүй “Ану-Сервис”, “Мон китурами” ХХК-иуд ажлыг гүйцэтгэсэн байна.

1.25 Шинээр суурилуулсан зуухнууд нь утааны үнс баригч төхөөрөмжтэй, бункер саванд байгаа нүүрс нь автомат удирдлагатай блокын хяналтан дор шаталт явагддаг, тусгай хөргөгч хэрэгсэл нь утааг шүүж гаргадаг нь өмнө ашиглаж байсан зуухнаас давуу талтай байна.

4. Газрын гүний дулааныг ашиглах дэд төсөл бараа, ажил үйлчилгээ худалдан авах аргыг хуулийн дагуу сонгоогүй байна.

1.26 НАЧА, НЗДТГ-ын СТСХэлтэс газрын гүний дулааныг ашиглах 100.0 сая төгрөгийн төсөл бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа “Степпе солар” ХХК-тай шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 34.1.1 дэх заалтыг зөрчиж байна.

1.27 Мөн “Степпе солар” ХХК-тай 2009 оны 7 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан газрын гүний дулааныг ашиглах тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах гэрээнд ажил гүйцэтгэх ерөнхий хугацааг 30 хоног гэж заасан боловч эхлэх хугацааг гадаад захиалгын тоног төхөөрөмжийн ирэх хугацаатай уялдуулан тогтооно гэжээ. Уг төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчээс 2009 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр техникийн комисс ашиглалтад хүлээн авсан боловч 2010 оны 1 дүгээр сарын 1-нээс тоног төхөөрөмжийг ашиглаж эхэлсэн байна.

1.28 Дээрх төслөөр суурилуулсан дулааны насосны тоног төхөөрөмжийг СХД-ийн 81 дүгээр цэцэрлэгийн салбар болох “Сод монгол” ХХК-ийн хандивын хөрөнгөөр баригдсан Сод цэцэрлэгт суурилуулжээ. Цэцэрлэгийн барилга, газар эзэмших эрх тухайн цэцэрлэгийн мэдэлд өнөөг хүртэл шилжээгүй байна.

1.29 Хүүхдийн цэцэрлэг жилд ойролцоогоор 85 тн орчим нүүрс хэрэглэдэг байсан бол газрын гүний дулааныг ашигласнаар жилд дунджаар 3262.5 мянган төгрөгийн зардал хэмнэх тооцоо гарчээ.

1.30 Үүнээс гадна тээврийн хэрэгсэлд шингэрүүлсэн нефтийн хийн тоног төхөөрөмж суурилуулах 190.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг зарласан боловч тендер хүлээн авах өдөр нэг ч санал ирээгүй тул “Юнигаз”, “ББНА” болон “Дашваанжил” ХХК-иудтай гэрээ байгуулж 200 автомашинд уг тоног төхөөрөмжийг суурилуулж төслийг хэрэгжүүлсэн байна.

1.31 Гэвч Улаанбаатар хотод нефтийн хий цэнэглэх станц цөөн байгаагаас автомашинууд шингэрүүлсэн хийг тогтмол хэрэглэх боломжгүй байгаа нь уг төслийн үр дүн хангалтгүй байна.

2010 оны төсвийн тухай хуулинд 5.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр тусгагдсан ч 2010 оны 9 дүгээр сарын байдлаар хөрөнгө зарцуулагдаагүй байна.

1.32 ЭБЭХЯ “ДЦС-2” ХК-ийг түшиглэн 210 мянган тн хагас кокжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай 17.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй цогцолбор үйлдвэрийг 2010-2012 онд байгуулах төсөл, арга хэмжээг төлөвлөж, 2010 оны төсвийн тухай хуулинд 5.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан байна.

1.33 ЭБЭХС-ын 2010 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 4 дүгээр тушаалаар төсөл, арга, хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж, тендерийн урилгыг 2010 оны 4 дүгээр сарын 3-нд Сангийн яамны веб сайт болон өдөр тутмын “Өдрийн сонин”, “Үндэсний шуудан” сонингоор зарласан боловч 1.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажлын тендерийн урилгыг ТБОНӨХБАҮХАТХуулийн 21.3-т заасны дагуу олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлээгүй байна.

1.34 Тендерийн баримт бичгийг “Аморе интернэшнл”, “Шарын гол”, “Зэлмэ” ХХК-иуд худалдан авсан боловч “Аморе интернэшнл” ХХК болон ОХУ-ын “Сибтермо” компанийн түншлэл саналаа ирүүлсэн байна.

1.35 Үнэлгээний хороо тендерийг хянан үзэж, тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтүүдийг Монгол Улсын “Аморе интернэшнл” ХХК болон ОХУ-ын “Сибтермо” компанийн түншлэл хангасан гэж үзэн гүйцэтгэгчээр сонгон шалгаруулжээ.


1.36 ЭБЭХЯ гүйцэтгэгчээр шалгарсан “Аморе интернэшнл” ХХК-тай 2010 оны 7 дугаар сарын 9-ний өдөр ДЦС-2 ТӨХК-ийг түшиглэн жилд 210 мянган тн кокжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах ажлын гэрээ хийж, 2010 онд 5.0 тэрбум төгрөг, 2011 онд 9.2 тэрбум төгрөг, 2012 онд 2.7 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр хуваарь хийсэн боловч төлбөрийг ямар нөхцлөөр хийх нь тодорхойгүй хөрөнгө зарцуулагдаагүй байна.

1.37 Мөн түүнчлэн хагас кокжсон нүүрсийг өрхийн хэрэглээнд хэрхэн ашиглах талаархи бэлтгэл ажил зохион байгуулагдаагүй байна.

Дүгнэлт:

- Боловсруулсан түлшний өртөг өндөр, борлуулалт муу, хэрэглээ нэмэгдэхгүй байна.
- Үртсэн шахмал түлшний иж бүрэн цогцолбор үйлдвэрийн үйл ажиллагаа жигдрээгүй, үйлдвэрийн удирдлага зохион байгуулалт хангалтгүй байна.
- Нийслэлийн Засаг даргын 2009 оны 309 дүгээр захирамжаар байгуулсан үнэлгээний хороо зарим тендерийг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.
- 2010 оны төсвийн тухай хуулинд тусгасан 5.0 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ хийсэн боловч төлбөр хийх болон ашиглалтын нөхцөл тодорхойгүй хөрөнгийг зарцуулаагүй байна.

ирүүлсэн санал:


МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
15160 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай 11,
Утас: 32-71-99, Факс: (976-11) 32-43-31
2010. 10. 14 № 242681
танай _____-ны № _____-г

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Ч.РАДНАА ТАНАА

Монгол Улсын Үндэсний Аудитын газраас
Утаа бага гаргах зориулалт бүхий түлш
боловсруулахаар төсвөөс санхүүжүүлсэн
хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын дүгнэлт зөвлөмжийн дагуу ажлын
төлөвлөгөө гарган тодорхой арга хэмжээнүүдийг
авч ажиллах болно.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой
зарим асуудлаар нэмэлт тодруулгыг хийж
хавсралтаар хүргүүлж байна.

ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКОЛОГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ
Д.ТАНБОЛД

Toot.ji
0200963

**Монгол Улсын Үндэсний Аудитын газраас Утаа бага гаргах зориулалт бүхий түлш
боловсруулахаар төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд
хийсэн аудитын тайлангийн төсөлд өгөх санал**

***Нийслэлээс аргаарын бохирдлын буруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга
хэмжээнүүд:***

Нийслэлд сүүлийн жилүүдэд олны анхаарал татаж байгаа асуудлын нэг нь өвлийн улиралд Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудал юм.

Судалгаанаас үзэхэд нийслэлийн агаарын бохирдлын дийлэнхи хувийг гэр хорооллын утаа эзэлж байгаа нь тогтоогдсон. Утааг арилгах нь цаг хугацаа шаардсан, хөрөнгө мөнгө их орох ажил боловч богино хугацаанд шийдвэрлэхээр бодлогоо тодорхойлон ажлын эхлэлийг тавьж байна.

Нийслэлээс Байгаль орчны яам болон холбогдох газруудтай хамтран “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө” боловсруулж батлуулан хэрэгжүүлж байна. Мөн агаарын бохирдлыг бууруулах талаархи эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийг боловсруулсан. УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг боловсруулан батлуулан ажиллаж байна.

Тус хөтөлбөрт гэр хорооллыг оршин суугчдынх нь оролцоотойгоор орон сууцны хороолол болгон хөгжүүлэх, хотын тоос, утаа, тортог, хог хаягдлыг багасгах, мод, зүлэг зэрэг ногоон байгууламжийн нэг хүнд ногдох хэмжээг 20 м² хүртэл нэмэгдүүлэх, гэр хорооллын айл өрхийн зуух-яндан-түлшний бүтэц, шаталтын технологийг өөрчлөн сайжруулах, нам даралтын уурын зууханд технологийн шинэчлэл хийх, нам даралтын уурын зуух, гэр хорооллын түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хязгаарлан, улмаар утаагүй түлш, шатдаг хий, цахилгаан эх үүсвэрээр ажилладаг шинэ технологи нэвтрүүлэх замаар утаа, хорт хийн ялгаралтыг 2013 он хүртэл хугацаанд 60 -аас доошгүй хувиар бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Утааг арилгах гол арга зам нь гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хороолол болгох явдал юм. Энэхүү асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан ажлын хэсэг гарч төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Эхний ээлжинд Улаанбаатар хотын салхины зонхилох чиглэлийн дээд талд байрлаж хотын төвийн утааг нэмэгдүүлж байгаа Радио телевизийн хэрэг эрхлэх газрын орчим, 7-р хороолол, Дэнжийн 1000, Баянзүрх дүүргийн 14-р хороолол, 7-р бичил хороолол, Дарь-Эхийн хорооллыг орон сууцны хороолол болгохоор Ерөнхий төлөвлөлөө, инженерийн шугам сүлжээний зураг, төсвийг боловсруулаад байна. Эдгээр хорооллуудад байрлаж байгаа 9300 орчим айл өрхийн талбайг барилгажуулснаар 43,0 мянга орчим айлын орон сууц баригдах боломжтой болно.

Мөн хот орчмын ашиглагдаагүй газарт шинээр орон сууцны хороолол байгуулах чиглэлээр Баянзүрх дүүргийн Ногоон зоорь орчим, Хан-Уул дүүргийн Буянт-Ухаа орчим, Сонгинохайрхан

дүүргийн Хотын шинэ байгуулах зураг төсвийг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна.

Нийслэлийн гэр хорооллыг дахин төлөвлөж, барилгажуулах, орон сууцжуулах бэлтгэл ажлын хүрээнд 2009-2010 онд дулааны 5б, 6б,в, 6г, 12б, 1б, 7в,7и, зэрэг томоохон дулааны магистрал 7 шугамыг өргөтгөл шинэчлэлтийн ажлыг дуусган, дулааны насос станц №1, 6-ын хүчин чадлыг нэмэгдүүлж, "Улаанбаатар" дэд станц, Умард дэд станцын өргөтгөл, шинэчлэлт, "Хайлааст" дэд станцаас Яргайт дэд станц хүртэл 35 квт-ын 2 хэлхээт 9 км цахилгаан дамжуулах шугам, "Дорнод-2" болон "Амгалан дэд станц"-ын хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлэх, ДЦС-3, 4 станцын техник, технологийн шинэчлэлтийн ажил, Баянзүрх дүүрэгт шинээр баригдах 14 дүгээр хорооллын дулаан, цэвэр, бохир усны 1,6 км хос шугам, Баянгол дүүргийн III-IV хорооллын 31-ийн III коллекторын 0,6 км, 22-р коллекторын 1,6 км бохир усны шугмын шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэхэд улсын төсвөөс 50,0 гаруй тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Гэр хорооллыг барилгажуулах зорилгоор дүүрэг бүрт гэр хорооллын айл өрхийг түр байршуулах, дамжин өнгөрүүлэх 300 айлын орон сууцыг барихаар төлөвлөж эхний ээлжинд Сүхбаатар дүүргийн 11-р хороонд 300 айлын орон сууц барих ажлыг нийслэлийн төсвөөс 2,5 тэрбум төгрөг зарцуулан ажлыг эхлүүлээд байна.

Дээрхи хөрөнгө оруулалтын үр дүнд нийслэлийн гэр хорооллыг дахин төлөвлөж барилгажуулах ажлын бэлтгэл хангагдаж байна.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2010 онд улсын төсвөөс 5,0 тэрбум төгрөгийг зарцуулан "ДЦС-II" ТӨХК-ийг түшиглэн 210 мянган тонн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах ажил эхлээд байна. Мөн нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Хялганат дахь Үртсэн түлшний үйлдвэрийг ашиглалтанд хүлээн аваад байна.

Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд нийслэлийн төсвөөс 2009 онд 3,2 тэрбум, 2010 онд 3,5 тэрбум төгрөг зарцуулаад байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах асуудлыг шийдвэрлэх нэг гарц бол хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ээлтэй сэргээдэх эрчим хүчийг өргөн ашиглах явдал юм. Иймд газрын гүний дулааныг дулаан хангамжид нэвтрүүлэх төслийг Монголд анх удаа "Степпсолар" ХХК-тай гэрээ байгуулан Сонгино-Хайрхан дүүргийн "СОД" хүүхдийн цэцэрлэгийг шинэ дэвшилтэт технологи, байгалийн сэргээгдэх эрчим хүч болох газрын гүний дулааныг дулаан хангамжид нэвтрүүлэх төсөл амжилттай хэрэгжин ашиглалтанд оруулсан.

Нийтийн тээвэрт цахилгаан тээврийн үйлчилгээг өргөжүүлэн 2009-2010 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10 электробус үйлдвэрлэн үйлчилгээнд гаргах ажил хийгдлээ.

“Петровис” ХХК болон “Оргил Ойл” ХХК-иуд хамтран авто тээврийн хэрэгслээс ялгарах утааны бохирдлыг бууруулах зорилгоор биоэтанол бүхий “ЭКО” бензиний хэрэглээг дэмжиж, экологийн цэвэр бүтээгдэхүүн ЭКО-92 шинэ бензинийг монголд анх удаа зах зээлд нэвтрүүлээ. “ЭКО-92” бензинийг автомашинд хэрэглэх явцад хөдөлгүүрийн эд ангиудад сайнаар нөлөөллөөд зогсохгүй, автомашины яндангаас ялгарах утаа, нүүрс хүчлийн дутуу исэлийн хэмжээ 30-40 %-аар бууруулж байгаа нь тогтоогдлоо.

Шингэрүүлсэн нефтийн хийн төхөөрмжийг нийтийн тээврийн хэрэгсэл болох такси баазын 200 хүртэлх автомашинд суурилуулахаар “Юниз Газ” ХХК, “ББНА” ХХК-иудтай гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар халаалтын зуухнуудыг шинэчлэх, засварлах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нийслэлээс агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж буй ч Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудлыг улсын хэмжээнд авч үзэн томоохон цогц арга хэмжээ авч бодлогын чанартай томоохон асуудлуудад хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

1. Үртсэн түлшний иж бүрэн цогцолбор, үйлдвэрийн талаар.

Нийслэлийн Засаг даргын 2009 оны 312 дугаар захирамжаар Улаанбаатар хотод сүүлийн үеийн технологийн үртсэн түлшний үйлдвэр байгуулах ажлыг Улаанбаатар бизнес хөгжлийн төвд үүрэг болгосон.

Нийслэлийн Засаг даргын 2009 оны 309 дүгээр захирамжаар Агаарын бохирдлыг бууруулах ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах Үнэлгээний хороо байгуулагдан ажилласан.

Тус үнэлгээний хорооны 2009 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар Үртсэн түлшний үйлдвэрт иж бүрэн тоног төхөөрөмж худалдан авч суурилуулах тендер зарлахаар шийдвэрлэсэн.

Үнэлгээний хорооны 2009 оны 8 дүгээр сарын 11-ны 06 дугаар хуралдаанаар тендерийн материалд зарим тодруулга хийх зайлшгүй шаардлага гарсан тул тендерт оролцсон аж ахуйн нэгжүүдэд дараах тодруулгыг хүргүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Үртсэн түлшний үйлдвэрийн барилга, цахилгаан хангамж, үйлдвэрийн иж бүрэн тоног төхөөрөмж худалдан авч суурилуулах болон бусад асуудлыг иж бүрнээр шийдвэрлэх,

2. Тендер ирүүлэх хугацааг 2009.08.14-ний өдрийн 11 цагаас өмнө ирүүлэх болгон өөрчлөх,

3. Үйлдвэрийн тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажлыг тендер шалгаруулалт хийж, гэрээ байгуулснаас хойш 2009.12.01-ны дотор дуусгах,

Дээрхи шийдвэрийн дагуу тендерт оролцсон аж ахуйн нэгжүүдэд тодруулгыг хүргүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэхь хэсэгт *“Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”* гэж заасны дагуу Үртсэн шахмал түлшний иж бүрэн цогцолбор үйлдвэр байгуулах нээлттэй тендерийн урилгыг Зууны мэдээ сонины 2009 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 1621 дугаарт тавьж нийтэд мэдээлсэн байна. /Зууны мэдээ сонины хувийг хүргүүлсэн/

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.4 дэхь хэсэгт *“Нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувиас хэтрээгүй нөхцөлд тендер шалгаруулалтаар худалдан авсан ажлын нэмэлт ажлыг хийх тохиолдолд дахин тендер шалгаруулалт явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн бол шууд гэрээ байгуулна”* гэж заасны дагуу Үртсэн түлшний үйлдвэрийн гадна хашааг барих 27,0 сая төгрөгийг тендер шалгаруулалтын хэмнэлтийн хөрөнгөөс гарган тендерт шалгарсан “Хялганат хангай”, “Номин холдинг” ХХК-ын хамтарсан “Хос гарьд” түншлэлтэй нэмэлт ажлын гэрээ байгуулан хийсэн.

Хялганат дахь Үртсэн түлшний үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад зайлшгүй шаардлагатай бэлэн бүтээгдэхүүний агуулах, машин механизм, тоног төхөөрөмж авах 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг НИТХ-ын 2010 оны 5/37 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Нийслэлээс цаашид Хялганат дахь Үртсэн түлшний үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

2. Нам даралтын халаалтын зууханд техник, технологийн шинэчлэлт хийсэн талаар:

Нийслэлийн Засаг даргын 2009 оны 309 дүгээр захирамжаар Агаарын бохирдлыг бууруулах ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах Үнэлгээний хорооны 2009.08.04-ний өдрийн хурлаар ХУД-ийн нэгдсэн эмнэлэг, БГД-ийн Сэтгэмж цогцолбор сургуулийн нам даралтын халаалтын зууханд техник, технологийн шинэчлэлт хийх ажлыг гүйцэтгэхээр ирүүлсэн компаниудын саналыг авч хэлэлцсэн байна.

Тэдгээр саналуудаас “Эрчим импекс” ХХК нь тендерт санал болгож байгаа зуух нь экологид ээлтэй, Европын холбооны улсуудын стандарт шаардлагыг бүрэн хангасан, үнийн саналын хувьд боломжтой, санхүүгийн чадавхи сайтай зэрэг үзүүлэлтээрээ тендерийн шаардлагыг хангаж байсан.

Тус компани нь нам даралтын зуухны усгралт суурилуулалт, засвар үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөл авахаар Эрчим хүчний зохицуулах газарт хандан хүлээгдэж байгаа тухай Эрчим хүчний зохицуулах газрын албан бичиг ирүүлсэн байсан.

Үнэлгээний хорооноос ХУД-ийн нэгдсэн эмнэлэг, БГД-ийн Сэтгэмж цогцолбор сургуулийн нам даралтын халаалтын зууханд техник, технологийн шинэчлэлт хийх ажлыг “Эрчим импекс” ХХК-иар гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж үзээд Үнэлгээний хорооны 2009 оны 08.05-ны өдрийн 06 дугаар зөвлөмжөөр БХБТГ-т гэрээ байгуулан ажиллахыг үүрэг болгосон.

БХБТГ нь “Эрчим импекс” ХХК нь нам даралтын зуухны усгралт суурилуулалт, засвар үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөл байхгүй тул гэрээ байгуулах боломжгүй гэж үзсэн байна.

Дулаан авах хугацаа ойртсон тул экологид ээлтэй, стандарт шаардлагыг бүрэн хангасан, үнийн саналын хувьд боломжтой зуухыг судлан “Ану сервис”, “Мон китурами” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

4. Газрын гүний дулааныг ашиглах төсөл арга хэмжээний талаар:

Үнэлгээний хорооны 2009 оны 07. 20-ны 03 дугаар зөвлөмжөөр Газрын гүний дулааныг ашиглах төсөл арга хэмжээний хувьд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Газрын гүний дулааныг ашиглах төслийг анх удаа нэвтрүүлж буй “Степпе солар” ХХК-тай шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.2 дахь хэсэгт “оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол” гэсэн заалттай нийцнэ гэж үзэж байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Тайлбар 1-ийг
үзнэ үү.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын саналд өгөх тайлбар:

Тайлбар 1

Степпе солар ХХК нь газрын гүний дулааны насосны тоног төхөөрөмжийг гаднаас нийлүүлдэг, уг төхөөрөмжийн оюуны өмчийн зохиогч биш учраас оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар шууд гэрээ байгуулсан гэх тайлбарыг хүлээн авах боломжгүй гэж үзлээ.

Зөвлөмж:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод:

1. “ДЦС-2” ТӨХК-ийг түшиглэн жилд 210 мянган тн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахаар шийдэгдсэн төслийн төлбөр хийх нөхцлийг тодорхой болгож санхүүжилт хийх асуудлыг шийдвэрлэн, төслийг яаралтай эхлүүлэх арга хэмжээ авах
2. Хагас коксжсон түлшийг айл өрхийн хэрэглээнд ашиглах бэлтгэл ажлыг зохион байгуулах

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаярт:

1. Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор зарцуулж байгаа хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний үр өгөөж, үр дүнг бодитой үнэн зөв тооцож байх
2. Боловсруулсан түлшийг иргэдэд сурталчлан таниулах, борлуулах, хэрэглээг нэмэгдүүлэх арга замыг судлаж, холбогдох арга хэмжээг авах
3. Үртсэн шахмал түлшний иж бүрэн цогцолбор үйлдвэр байгуулах тендерийн баримт бичгийг холбогдох хуулийн дагуу иж бүрэн боловсруулаагүй үнэлгээний хорооны гишүүдэд хариуцлага тооцох



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2010 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Утаа бага гаргах зориулалт бүхий түлш боловсруулахаар 2009, 2010 онуудад төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсүгэй.

Гурав. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, дүнг 2011 оны 2 дугаар сард Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаярт зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын тайланд тусгагдсан зөрчлийн барагдуулалт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

073285